



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/316

Есөнбулаг сум

Согтууруулах ундаа худалдах түүгээр,
үйлчилгээ эрхлэхийг түр хугацаагаар
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хориглосугай.

2. Хориглосон өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ